

УЛСЫН ШАЛГАЛТ-2025

МОНГОЛ ХЭЛ V АНГИ



САНАМЖ, ЗӨВЛӨМЖ

- Шалгалт 60 минут үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан бүх даалгаврыг гүйцэтгээрэй.
- Шалгалтын материал нь сонгох хариулт бүхий тест, задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдэнэ.
- Сонгох хариулттай даалгаврууд тус бүр 1 оноотой байна.

А ХУВИЛБАР

СУМ:.....

СУРГУУЛЬ:

АНГИ: БҮЛЭГ:

ОВОГ:

НЭР:

**5 ДУГААР АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
А ХУВИЛБАР**

Хугацаа 60 минут

Нийт оноо –25

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Мөчирхөн

Өнөөдөр нар ээсэн таатай сайхан өдөр байлаа. Болдоо цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалж явтал өөрөөс нь ялимгүй өндөр ургасан зулзаган мод түүний анхаарлыг татав. Үгүй мөн гоёо? Үүгээр чинь чавх хийе гэж бодов. Тэгээд тэр зулзаган модны нэг мөчрийг хугалан авчихлаа.

-За хүү минь яаж байгаа юм бэ? гэх дуунаар эргэн хартал цэцэрлэгч өвөө ирсэн байв. Болдоог хариу хэлэхийг ч хүлээсэнгүй:

-Чиний гар хөлийг гэмтээвэл өвдөх үү? гэж асуув

-Өвдөнө. -Цус гарах уу?

-Гарна.

-Тэгвэл энэ модноос шүүс гарч байна уу?

-Тийм ээ. Шүүс гарч байна.

-Энэ мод та хоёр яг адилхан балчир шүү дээ. Эргэн тойронд ургасан өндөр модыг үүний эх эцэг нь ч гэж бодож болно.

Тэгэхээр хүүхдийнх нь нэг мөчрийг өвтгөчихжээ. Чи үүнээс хойш битгий ингэж байгаарай гэж хэлээд, хөрс сийрүүлэх ажлаа хичээнгүйлэн хийж байв. Болдоо тасалж авсан мөчрөө нэг хараад, зулзаган модоо нэг хараад хэсэг хугацаанд бодолд автав. Нээрээ л тусгүй юм болж дээ.

Өмнө нь гараа эсгэхэд ээж нь түүнийг **самбай**гаар боож эдгээснийг санаад, гэр лүүгээ харайлгалаа. Зулзган модны хугарсан мөчрийг нь ээж шигээ үлээж: - Удахгүй эдгэнэ мөчирхөн минь. Битгий гомд гээд боов. Болд мөчрөө өдөр болгон ирж хардаг ч мөчир эдгэрсэнгүй, ургасангүй. Бусад мөчрийнх нь навч бүгд дэлбээлж гүйцээд байхад боолттой мөчирхөн уйтгартай нь аргагүй хатаж ганджээ. Болдоо цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалж явахад урьдын адил сайхан агаар, чийглэг уур амьсгал үгүй болсон мэт санагдаж байв. Модны салаа мөчир бүрийг хайрлан хамгаалах ёстойг маш сайн ойлгож ухаарлаа.

1. Эхэд байгаа тодруулсан үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг олж сонгоорой.

/ 1оноо /

- A. Нарийн уяа
- B. Сийрэг нэхээстэй нимгэн эд
- C. Хөвөн даавуу
- D. Цаас

2. “Мөчрийн хатаж гандах болсон” учир шалтгаан юу байсан бэ? /1оноо /

- A. Нартай сайхан өдөр байсан.
- B. Зулзаган мод түүний анхаарлыг татсан.
- C. Цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалсан.
- D. Чавх хийе гэж бодон мөчрийг хугалсан.

3. Балархай эгшиг нь гээгдэх дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой. /1 оноо/

- A. саналыг, бургасыг, заншлыг, үзлийг
- B. заншлыг, үзлийг, төслийг, зургийг
- C. үзлийг, эрдэнийг, саналыг, заншлыг
- D. шанагаар, эрдэнийг, бодохоор, түмнийхээ

4. Үүр+л=Үүрлэ ижил дүрмээр бичигдэх үгийг олоорой.

- A. Мөнгө+л=
- B. хоол+л=
- C. дуу+л=
- D. ус+л=

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

5. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй. /4 оноо/

А. Эхийн гол санааг бичээрэй./2 оноо/

.....

.....

.....

В. Бичсэн эхийн гол санаагаа зохиогчийн хэлэх гэсэн санаатай холбон тайлбарлаарай.
/2 ноо/

.....

.....

.....

.....

6. Хүснэгтэд Болдоогийн зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй. / 3 оноо /

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
.....	
.....	
.....	
.....	
Яагаад өөрчлөгдөх болсон бэ?	
.....	
.....	
.....	
.....	

7. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

А. Болд зулзаган модны мөчрийг яагаад хугалсан бэ?

.....

.....

В. Хэрэв чи Болдын оронд байсан бол яах вэ? Яагаад ? Зулзаган модны мөчрийг хугалаагүй бол юу болох байсан бэ? Өөрийн үгээр төсөөлөн бодож, тайлбарлан бичээрэй. /4 оноо /

.....

.....

.....

.....

УЛСЫН ШАЛГАЛТ-2025

МОНГОЛ ХЭЛ V АНГИ



САНАМЖ, ЗӨВЛӨМЖ

- Шалгалт 60 минут үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан бүх даалгаврыг гүйцэтгээрэй.
- Шалгалтын материал нь сонгох хариулт бүхий тест, задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдэнэ.
- Сонгох хариулттай даалгаврууд тус бүр 1 оноотой байна.

Б ХУВИЛБАР

СУМ:.....

СУРГУУЛЬ:

АНГИ: БҮЛЭГ:

ОВОГ:

НЭР:

5 ДУГААР АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
Б ХУВИЛБАР

Хугацаа 60 минут

Нийт оноо –25

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Чулуун цуглуулга

Өнөөдөр аравдугаар сарын нэгэн миний хорвоод мэндэлсэн баярын өдөр билээ. Хамгийн түрүүнд нагац эгч маань “Эрмүүн ээ, Төрсөн өдрийн баярын мэнд хүргэе. Ээж аавдаа энэрэлтэй, эмээ өвөөдөө асралтай, эх орондоо ээлтэй сайн хүн болоорой” гэж ерөөн, ном, хайрцагтай чихрийн цуглуулга бэлэглэлээ. Миний хайртай зохиолчийн шинэхэн гарсан номыг бэлэглэсэнд хөл газар хүрэхгүй байв. Энэ үед Тулга найз маань манайд ирлээ. Би ч найзтайгаа чихрийн цуглуулгаа хувааж идэхээр гаргаж ирвэл “

Хөөе, Эрмүүн ээ! Надад нэг санаа төрлөө. Хоёулаа чулуун цуглуулга хийе. Тиймээс чихрийн цуглуулгаа болгоомжтой задална шүү” хэмээн нүдээ онилгон инээлээ. Ингээд чихрийн цуглуулгаа идэж дуусаад, оронд нь өнгө өнгийн чулуу хийгээд, буцаагаад наачихлаа. Анзаарга муутай хүн бол мэдэх ч үгүй гэдэгт итгэлтэй байлаа. Тулга сургуулийн хашааны хаалганы ойролцоо хайрцагтай чулуун цуглуулгаа тавиад, холгүйхэн газраас хоёул ажиглан харж, зогсохоор болов. Тэгтэл юу болсон гэж сананаа. Эхлээд үйлчлэгч Долгор эгч хөлөөрөө өшиглөчхөөд явчихлаа. Дараа нь биеийн тамирын багш тоож харсан ч үгүй хажуугаар нь гараад явчхав. Харин манай хөрш айлын ах Батсуурь өшиглөж үзсэнээ газраас авч, эргүүлж тойруулж хараад, шууд л өвөртөө хийчхэв.

Тулга бид хоёр чулуун цуглуулга эзэнтэй болсонд элгээ хөштөл инээж, Батсуурь ахынд очихоор боллоо. Гэрт ортол бид хоёрын цуглуулж хийсэн хэдэн хөх чулуу хоймор нь шидээстэй. Нараа эгч уйлчихсан. Батсуурь ах хэрэг хийсэн хүүхэд аятай **дүмбийгээд** сууж байна. Тэдний байдлыг харвал Батсуурь ах маань олж өвөртөлсөн цуглуулгаа Нараа эгчид өгсөн нь илт байв. Нараа эгчийгээ уйлуулсандаа би харамслаа. Тун тоогүй юм хийлээ дээ. Дэмий л Дөлгөөнөөс тооны номыг нь авах гэсэн юм гэвэл хөөрхий муу Нараа эгч нулимсаа гарынхаа араар арчин, хүүгийнхээ цүнхнээс тооны ном авч надад өглөө. Сэтгэл өвдөх шиг. Ахиж би хэзээ ч хүн хуурахгүй ээ. Зүггүйтэж хийсэн тэр чулуун цуглуулга ямар муухай хор уршигтай байсныг бодохоор одоо ч нурууны хөлс гардаг юм.

1. Эхэд байгаа тодруулсан үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг олж сонгоорой. / 1 оноо /
 - A. Гуниглан суух
 - B. Баярлан суух
 - C. Дүлий мэт дуугүй байх
 - D. Маш их айсан
2. “Ахиж би хэзээ ч хүн хуурахгүй ээ” гэж хэлсний учир шалтгаан юу байсан бэ? / 1 оноо /
 - A. Нараа эгчийгээ хуурч уйлуулсандаа харамссан.
 - B. Нагац эгч нь хайрцагтай чихэр бэлэглэсэн.
 - C. Үйлчлэгч Долгор эгч чихэрийг нь өшиглөсөн.
 - D. Батсуурь ах нь хайрцагтай чихрийг өвөртөлсөн.
3. Залгавар залгахад балархай эгшиг нь гээгдэхгүй үгийг олоорой. / 1 оноо /
 - A. өвдөх, сэтгэл, зогсох, үзсэн
 - B. чихэр, хүүхэд, байдал, эгч
 - C. өнөөдөр, Долгор, хураах, сайн
 - D. газар, хайрцаг, уйлсан, Нараа

4. Хоол+л=Хоолло ижил дүрмээр бичигдэх үгийг олоорой. /1 оноо/

- A. ус+л=
- B. бүлэг+л=
- C. морь+л=
- D. цай+л=

5. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй. /4 оноо/

A. Эхийн гол санааг бичээрэй./2 оноо/

.....

.....

.....

B. Бичсэн эхийн гол санаагаа зохиогчийн хэлэх гэсэн санаатай холбон тайлбарлаарай.
/2 оноо/

.....

.....

.....

6. Хүснэгтэд Эрмүүний зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй / 3 оноо /

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
.....	
.....	
.....	
.....	
Яагаад өөрчлөгдөх болсон бэ?	
.....	
.....	
.....	
.....	

7. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй. /4 оноо/

A. Эрмүүн чулууг яагаад хайрцганд хийх болсон бэ? /1 оноо/

.....

.....

B. Хэрэв чи Эрмүүний оронд байсан бол яах вэ? Яагаад ? Чулууг чихрийн хайрцганд хийгээгүй бол яах байсан бэ? Өөрийн үгээр төсөөлөн бодож, тайлбарлан бичээрэй. /3 оноо/

.....

.....

.....

.....

